



# REACH

## ТӨСӨЛ



Малчин өрхүүд, тэдний хүүхдүүдэд зориулсан боловсрол, хүүхэд хамгаалал, эрүүл мэндийн хүмүүнлэгийн тусламжийн төсөл

## Үндсэн зорилго:

Зудад нэрвэгдсэн, алслагдсан аймгийн малчин өрхүүд, тэдгээрийн хүүхдүүдийн боловсрол, эрүүл мэнд, хүүхэд хамгааллын зарим хэрэгцээг хангах гол зорилго бүхий "REACH" хүмүүнлэгийн тусламжийн төслийг Баян-Өлгий, Ховд аймагт Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Элчин сайдын яамны голлох санхүүжилтээр Пипл ин Нийд олон улсын төрийн бус байгууллага хэрэгжүүлж байна.

## Үйл ажиллагаа:

### Сургалтын хэрэгсэл, амин дэмийн багц:

270 өрхийн 540 хүүхэд, 18 сургуулийн дотуур байранд амьдарч буй 2,860 хүүхэд, нийт 3,400 хүүхэд сургалтын хэрэглэгдэхүүн болон амин дэмийн багц түгээнэ.

### Хүүхэд хамгааллын эрсдэлийн үнэлгээ:

Зорилтот сумдын алслагдсан, зудын хүндрэлд өртсөн, хүүхэд хамгааллын эрсдэлтэй байж болзошгүй 270 малчин өрхөөс гадна 18 сургуулийн дотуур байранд хүүхэд хамгааллын эрсдэлийн үнэлгээ хийнэ.

### Бэлэн мөнгөний дэмжлэг:

270 малчин өрхөд хүүхдүүдийнхээ боловсрол, эрүүл мэндийн хэрэгцээг нь хангахад чиглэсэн 660,000 төгрөгийн тусламж үзүүлнэ.

### Хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулах заавар, зөвлөгөө:

Хүүхэд хамгааллын эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан 270 малчин өрхийн эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд болон 18 сумын сургуулийн удирдлагуудад тогтоогдсон эрсдэлийг бууруулах, арилгах зөвлөгөө өгөх, хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг гүйцэтгэнэ.


### Төслийн хэрэгжилт:

Төслийг орон нутаг хэрэгжүүлэх ажлыг Баян-Өлгий, Ховд аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (ХБХГХГ) хариуцан ажиллаж байна.

## ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:



## ЗОРИЛТОТ СУМ:




## ХУГАЦАА:


- 2024 оны 5-р сарын 17-ны өдрөөс  
2024 оны 10-р сарын 31 хүртэл


## ҮР ШИМ ХҮРТЭГЧИД:


- 270 малчин өрх
- 3,400 хүүхэд
- 18 сумын сургууль
- Баян-Өлгий аймгийн Дэлүүн, Толбо, Алтай, Буянт, Сагсай, Улаанхус, Цэнгэл, Ногооннуур, Баяннуур
- Ховд аймгийн Алтай, Булган, Үенч, Мянгад, Мөнххайрхан, Мөст, Дөргөн, Дарви, Цэцэг сум


## Төслийн явцын үр дүн:


 **2** орон нутгийн түнш:  
Бид Баян-Өлгий, Ховд аймгуудын Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас гадна сумдын хүүхэд хамгааллын хамтарсан багтай хамтран ажиллаж байна.

 **46** Хүүхэд хамгааллын эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн хүрээнд, чанартай хийхэд нь туслах үүднээс 1.5 өдрийн "Хүүхэд хамгааллын эрсдэлийн үнэлгээ хийх арга зүй" сэдэвт сургалтыг хүүхэд хамгааллын мэргэжилтэн, хамтарсан багийн 46 гишүүнд зохион байгууллаа.

 **270** малчин өрхөд хүүхдүүдийнхээ боловсрол, эрүүл мэндийн хэрэгцээг нь хангахад чиглэсэн

 **367** Хүүхэд хамгааллын эрсдэлийн үнэлгээнд 367 малчин эцэг эх, асран хамгаалагч хамрагдаж, эрсдэлийг бууруулах мэдээлэл, зөвлөгөө авлаа.

 **30** Хүүхэд хамгааллын эрсдэлийн үнэлгээний үр дүнд 30 хүүхдийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилсан.

 **9** Хүчирхийлэлд өртсөн 9 хүүхдийг илрүүлж, кейс нээсэн.



# 660,000

төгрөгийн бэлэн мөнгөний тусламж үзүүлээ.